



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДУГНЭЛТ**

306 дугаар байр, Чандмань гудамж 3,
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442114, 70442088
Цахим шуудан: ghbhbgazar@gmail.com
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2023.04.27 № 02-16-01/052/05

Г

Барилга ашиглалтын тухай

Г

Танаас ирүүлсэн хүсэлт, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Барилга техникийн хяналтын улсын байцаагч Ч.Сарайдамба Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын конторын барилгын ашиглалтын төлөв байдалд Барилгын тухай хууль, Барилга ашиглалтын дүрэм болон холбогдох норм, стандартын хэрэгжилтийг холбогдох хүмүүсийг байлцуулан 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр шалгалт хийлээ.

Тус барилга нь 1995 онд эмнэлгийн зориулалтаар ашиглалтад орж, 2002 он хүртэл халдвартын эмнэлгийн үйл ажиллагааг явуулж байсан, шугаман цутгамал суурьтай, хүрмэн гулдмайн ханатай, угсармал төмөр бетонон хучилттай, хуйлмал хавтгай дээвэртэй, төвлөрсөн цахилгаан хангамж, халаалт, төвлөрсөн цэвэр усан хангамж, ариутгах татуургад холбогдсон, тэнхлэгээрээ 12x45,4м хэмжээтэй, 2 давхар болно. Ашиглалтад орсноос хойш иж бүрэн их засвар хийгдээгүй, барилгын хүчин чадал хүрэлцдэггүй. Шалгалтаар:

1.Барилгын суурийн 5 газарт 0,5-3мм-ийн хагарал үүссэн, хаяавчийн 30 гаруй хувь нь хагарч бутарсан, суурь луу хурын ус орж гэмтэл үүсэх нөхцөл бүрдсэн нь “Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан зааврын холбогдох заалтыг,

2.Барилгын цахилгааны шугам сүлжээ гэмтэлтэй, хэрэгслүүд эвдэрсэн, хуучирсан нь “Хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрмийн” холбогдох заалтыг,

3.Дээврээс байнга хурын ус гоожсоны улмаас өрөөнүүдэд хөгц, мөөгөнцөр үүссэж, хийцлэлүүд хэв гажилтад орсон нь Дээврийн ажил БНБД31-07-05-ын холбогдох заалтыг,

4.Барилгын шал, хана, цонхоор дулаан алддаг, хойд талын өрөөнүүд нар үздэггүй учир хүйтэн, халаалтын шугам хоолой цоорсон ус их алддаг, өрөөнүүдийн халаалтын секцний тоо цөөхөн зэрэг нь “Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер” БНБД41-01-11-ийн 7 зүйлийн холбогдох заалтуудыг, Барилгын хуванцар /PVC/ цонх, хаалга Техникийн шаардлага MNS 5830:2007-ын холбогдох заалтуудыг,

5.Цэвэр усны шугам хоолой гэмтэлтэй, хэрэглээний халуун ус байхгүй нь “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013-ын холбогдох заалтуудыг,

6.Агааржуулалтын систем байхгүй нь Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын заалтуудыг,

7.Хаалга, шал элэгдэж, гэмтсэн, барилгын гадна, дотор шавардлагад ан цав, зай завсар үүссэн, ханын будаг, шохой ховхорсон, заслуд өнгө үзэмжээ алдсан нь Заслын ажил БНБД31-10-05-ын холбогдох заалтууд,

8.Эмийн нөөцийн өрөө нь 6м^2 хэмжээтэй байгаа нь MNS5260:2015 стандартын шаардлагыг хангадаггүй.

9.Зориулалтын агуулахгүй, дархлаажуулалтын өрөөний тоо цөөхөн, хүрэлцдэггүй, вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгслийн агуулах, вакцины өрөө, хүлээлгийн өрөөнүүд байхгүй.

10.Нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах зориулалтын заал, танхим байхгүй нь Эрүүл мэндийн тухай хууль, салбарын холбогдох стандартууд, Барилгын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1/механик аюулгүй байдлыг хангах, барилга байгууламжийн материал, хийц, бүтээц, эдлэхүүн нь барилгын ажлын болон ашиглалтын үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой байх /заалтыг, Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03-ын заалтуудыг, Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03-ын заалтууд тус тус хангагдахгүй байна.

Дээрх байдлыг үндэслэн **ДҮГНЭХ** нь: аймгийн Эрүүл мэндийн газрын конторын барилга нь салбарын стандарт, шаардлагуудыг хангахгүй байгаа тул шинээр төлөвлөх шаардлагатай.

БАРИЛГА ТЕХНИКИЙН ХАНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
БҮГДЭМЖ
2016-01/052
С.САРАЙДАМБА

